

МОНГОЛ ӨРХ /ГЭР/ БҮЛИЙН ТҮҮХ СУДЛАЛЫН АСУУДАЛД

Т.Намжил¹

“Орчин үеийн нийгмийг ойлгохын тулд... гэр бүлийн нөхцөл байдлыг сайн мэдэх хэрэгтэй бөгөөд тэгвэл хуучны гэр бүлийг ойлгож баймааж нь орчин үеийн гэр бүлийг сайн мэдэж болно”

ЦУКИШИМА
КЕНЗО.

- Өрх гэрийн түүх судлалын үүсэл
- Монгол Өрх гэр /бүл/-ийн үүсэл
- Монгол Өрх гэрийн түүх судлал

ӨРХ ГЭРИЙН ТҮҮХ СУДЛАЛЫН ҮҮСЭЛ

Өрх гэр бүл бол юуны өмнө нийгмийн түүхэн үзэгдэл. Нийгмийн үзэгдэл болохын хувьд Өрх бүл нь хүй нэгдлийн нийгэмд үүсчээ.

XIX зууны сүүлийн хагасаас нийгэм судлаачид /И.Я. Бахофен, Швецари : Дж.Мах-Леннан Их Британи; Э.Вестермарк, Финлянди : Л.Г.Морган, АНУ : М.Ковалевский, Орос гэх мэт/ гэр бүл, өрх бүлийг нийгмийн байгуулал, соёлтой холбон үзэх болжээ.

Дэлхий дахинаа Өрх гэрийн түүх судлах явдал Бахофены “Эхийн эрхт ёс” гэдэг ном хэвлэгдэн гарсан 1861 оноос эхэлжээ.

Бахофен /Bachofen/, Иоган Якоб /1815-1887/
Швецарын нэрт түүхч, хууль цаазын мэргэжилтэн.

Бахофен зохиолдоо Өрх гэрийн үечлэлийг :

1. Анх эхлээд хүмүүс эр эмийн ямарч хязгааргүй харицаатай /үүнийгээ “завхайрал” гэсэн оновчгүй үгээр илэрхийлсэн байдаг/

2. Уг гарлыг зөвхөн эмэгтэйчүүдийн шугамаар, эхийн эрхт ёсны дагуу тогтоож болох байв – гэж үзсэн нь Өрх гэрийн түүхийн үечлэлийг тогтоох эхлэлийг тавьсаны ач холбогдол болжээ.

Гэхдээ Бахофен “завхайрлаас” моногам /ганц эхнэртэй юм уу нэг эртэй байх/ ёсонд буюу эхийн эрхт ёсноос эцгийн эрхт ёсонд шилжин хөгжсөнг Грекчүүдийн жишээн дээр авч үзэхдээ “хуучин үзлийн илэрхийлэгч бурхан тэнгэрүүдийн уламжлалт хэсгийн дотор шинэ үзлийн

1. Монгол Улсын Их Сургууль

төлөөлөгчид болсон шинэ бурхад бий болж хуучин бурхад улам бүр шахагдан буурсны улмаас” болсон, өөрөөр хэлбэл шашны ойлголтын цаашдын улмаас гэм шашны нөлөөтэй холбосон байна.

Гэхдээ Бахофен Өрх гэрийн судлалд шинэ зам нээсэн судлагч гэгдэх гавьяатай хүн юм. “Бахофен эр эмийн замбараагүй харилцаатай үл мэдэгдэх балар эртний байдлын тухай хоосон ярианы оронд Грекүүд ба Азийн ард түмнүүдийн дотор ганц эхнэртэй /эртэй/ байх ёс тогтохоос өмнө ёс заншилыг өчүүхэн ч гажуудуулалгүйгээр эрэгтэй хүн хэд хэдэн эмэгтэйтэй эр эмийн харилцаатай байсан төдийгүй бас эмэгтэй хүн хэд хэдэн эрэгтэй хүнтэй үнэхээр бэлгийн харилцаатай байсныг нотлох нотолгоо эртний үеийн сонгодог зохиолд олон байгааг анх удаа батлан харуулжээ.”² Бахофены ойрын залгамжлагч нь Ж.Ф.Мак-Леннон байжээ. Тэрээр Шотландын хөрөнгөтний хууль цаазны мэргэжилтэн, шүүхч юм. Гэрлэлт, гэр бүлийн талаар нэлээд ном бичжээ.

Мак-Леннон /1827-1881/-ы нэг гавьяа бол экзогам /овог дотроо гэрлэх явдал нь хориотой/ гэж өөрийнхөө нэрлэсэн тэр зүйлийг газар сайгүй дэлгэрч, их учир холбогдолтой байсныг заан тэмдэглэсэн, өөр нэг гавьяа эхийн эрхт ёсны дагуу уг гарлыг тоолох журмыг анхны журам гэж зөвшөөрсөн явдал юм.

Мак-Леннаныг Өрх гэрийн түүхийн үндсийг тавигч, энэ талаар хамгийн их мэддэг хүн гэж үздэг болжээ.

XIX зууны ховор зохиолуудын нэг “Эртний нийгэм” /1877 он/ бүтээлийг Лоюис Генри Морган бичжээ.

Морган /Morgan/, Льюис Генри /1818-1881/

Амеркийн нэрт эрдэмтэн, анхны хүй нэгдлийн нийгмийн түүхч,
аяндаа гарсан материалист.

Морганы гавьяа, нээлтийн ач холбогдлыг дурдах нь илүүц зүйл гэж үзээд түүний Өрх гэрийн түүхийн судлалд оруулсан хувь нэмэр юу вэ? гэдгийг анхаарах ёстой. Тухайлбал, Морган эхийн эрхт ёсны дагуу зохион байгуулагдсан Индианчуудын омог нь анхдагч хэлбэр байсан ба тэр омгоос эцгийн эрхт ёсны дагуу зохион байгуулагдсан нилээд хожмын омог хөгжиж гарсан хэлбэрийг нээжээ.

Эцгийн эрхт ёсон дээр үндэслэсэн омгийн урьдах шат болсон эхийн эрхт ёсон дээр үндэслэсэн анхны омог байсан явдал юм.

Чухам эндээс балар эртний Өрх гэрийн түүх судлалын шинэ үндэс эхэлсэн гэж үзэж болно. Өрх гэрийн түүх судлалд Морганы оруулсан систем гол чухал үндэслэл болсоор байна. Ф.Энгельс Морганы нээлтийн ач холбогдлыг дүгнэхдээ “Эхийн эрхт ёсон дээр үндэслэсэн омог энэ бүх л шинжлэх ухааны гол иш үндэс болов. Энэ омог нээгдсэн цагаас хойш ямар чиглэлээр юуг судлах, олж авсан үр дүнгээ хэрхэн яаж ангилах ёстой нь ойлгомжтой болов.”³ гэжээ.

Морганы зарим нэг таамаглал эргэлзээтэй болсон буюу няцаагдах явдал гарсан ч, түүний гол чухал үндэслэлүүд хэвээр. Балар эртний өрх гэрийн түүх судлалд Морганы оруулсан систем гол шинж байдлаа хадгалсаар байна.

Ф.Энгельсийн “Өрх гэр, хувийн өмч, төрийн үүсэл” зохиол нь Өрх гэр бүл, нийгэм-эдийн засгийн харьцаа, холбоо шүтэлцээг нарийвчлан задлан шинжилжээ.

Өрх гэрийн түүх судлалд гол байр эзэлсээр ирсэн зохиол бол 1884 онд Ф.Энгельсийн бичсэн “Өрх гэр, өмч хөрөнгө, төрийн үүсэл” зохиол юм. Энэ зохиолд Энгельс өөртөө байсан баримт,

2. Ф.Энгельс. Өрх гэр, хувийн өмч, төрийн үүсэл. /К.Марко, Ф.Энгельс. Түүвэр зохиол. III. УБ., 1971.232 дахь тал/

3. Ф.Энгельс. Дурьдсан зохиол. 239 дэх тал.

Т.Намжил

Морганы номонд орсон зарим дүгнэлт, материал дээр үндэслэн нийгэм-эдийн засгийн янз бүрийн байгууллын үеийн гэр бүлийн харилцааны хөгжлийн үе шат, онцлог, нийгэм, эдийн засгийн харьцаа, холбоо шүтэлцээг нарийвчлан задлан шинжилжээ.

Квалевский /1851-1916/ Оросын эрдэмтэн, улс төрийн зүтгэлтэн, хөрөнгөтний либерал, анхын хүй нэгдлийн байгууллын түүхийн талаар олон шинжилгээ судалгаа хийжээ.

Өрнөдөд XX зууны эхэн үеэс Өрх бүлийн судалгаа идэвхижжээ. Өрх бүлийн социологийн судалгааны үндэс тавигдсан байна. Тухайлбал, Н.Фрут, Р.Мейерзен нар Өрх бүлийн социологи /The Family Sociology/ Ле-Плейээс Өрхийн төсвийг судлахаас эхэлсэн. Ф.Энгельс орлого нэмэгдэхийн хэрээр хээнцэр тансаг зүйлст зарцуулах зарлага ихэсч, зайлшгүй хэрэгцээтэй зүйлсийг худалдаж авахад зарцуулах зарлага буурч байдгийг тогтоосон байхад, Э.Дюр-Кгейль нэг өрхөд багтах ам бүлийн тоо улам багасах хуулийг томъёолжээ.

Өрх бүлийн социологич Ч.Кул /Америк/ "Нийгмийн зохион байгуулалт" /1909 он/ номондоо Өрх бүлийг бусад анхдагч болон хоёрдогч бүлгүүдтэй харилцан үйлчилж буй "онцгой анхдагч бүлэг" гэж үзсэн нь чухал нөлөө үзүүлсэн байна. Тухайлбал "Анхдагч бүлэг" болохын хувьд Өрх бүл нь хоёрдогч бүлгүүдээс дараахи 2 шинжээр ялгаатай ажээ. Үүнд :

1. Өрх гэр бүл нь хүнд бүх талаар нөлөөлөх нөлөөллөөрөө цаг хугацаа хийгээд агуулгын хувьд хамгийн анхдагч нь бөгөөд бие хүнийг бүхэлд нь төлөвшүүлдэг. Тэгвэл хоёрдогч бүлгүүд /нийгмийн харилцаа/ нь түүнд зөвхөн тодорхой хүрээнд л нөлөө үзүүлдэг.

2. Өрх бүл бол "өөрөө өөрийгөө нөхөн үйлдвэрлэдэг" хүмүүсийн хамгийн дотно "холбоо", "хоршоо" юм гэжээ.

Амеркийн социологич Дж.П.Мэрдок "Нийгмийн бүтэц" /1949 он/ хэмээх номондоо эхнэр, нөхөр хоёр болон тэдний насанд хүрээгүй хүүхдээс буй болсон өрх бүл /"цомхон өрх бүл" буюу "өрх бүлийн цөм"/ бол анхны хүй нэгдлээс өнөөдрийг хүртэлх хүн төрөлхтний бүх нийгэмд хаа сайгүй тохиолдож байгаа элемент мөн гэсэн дүгнэлт хийсэн байна. Р. Хиллийн Өрх бүлийн тогтолцоо /система/ хэмээн тайлбарласан онол өдгөө өргөн түгэн дэлгэрчээ. Ийнхүү Өрх бүлийн түүх судлах нийгмийн сэтгэл судлалын үндэс суурь, үзэл баримтлал бүрэлдэн тогтсон байна.

"Өрх гэрийн түүх судлах явдал Бахофены «Эхийн эрхт ёс» гэдэг ном хэвлэгдсэн 1861 оноос эхэлжээ"

Ф.Энгельс

Одоогоос 150-иад жилийн тэртээх үеэс Өрх гэрийн түүхийг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах эхлэл тавигдаж, нэрт судлаачид бий болжээ.

Өрх гэрийн түүхийн гол зохиолууд гарсан үеэс хойшхи хугацаанд өрх гэрийн судлалын талаархи материал, баримт баяжигдаж, хүн судлал, эдийн засаг гээд олон талын судалгаа хийгдэж зохиол бүтээлүүд олонтаа гарч 100 гаруй жилийн үеэс дэвшигдэж байсан зарим таамаглал эргэлзээтэй болсон буюу няцаагдсан авч Н.Я.Бахофон, Л.Г.Морган, Ф.Энгельс, М.М.Ковалевский гээд судлаачдын дэвшүүлсэн гол чухал үндэслэлүүд хэвээр, улам баяжигдсаар байна.

МОНГОЛ ӨРХ ГЭР /БҮЛ/-ИЙН ҮҮСЭЛ

Монгол гэрийн үүсэл, хөгжлийн тухай дотоод, гадаадын эрдэмтэд судлаачид, ялангуяа Монгол Улсын эрдэмтэдээс багагүй судлагаа хийгдсэн авч, нүүдэлч Монголчуудын Өрх гэр /Гэр бүл/ чухам хэзээнээс үүсэлтэй болохыг тухайлан анхаарсангүй. Өрх гэрийн үүсэл, хөгжил нь нийгмийн түүхийн нарийн төвөгтэй үзэгдлүүдийн нэг мөн. Бид нүүдэлч Монголчуудын Өрх гэрийн үүслийн түүхийг төв Азид амьдарч байсан эртний өвөг дээдсийн хөдөлмөр, оюунаар

бүтсэн эд өлгийн биет хэрэглэгдэхүүнд тулгуурлан судлах зорилгыг тавьж байгаа юм.

Зохиогч Монголчуудын Өрх гэр /Гэр бүл/-ийн үүслийн талаар “Монгол гэр бүл” цуврал бүтээлийн хүрээнд “Монгол гэр бүлийн ёс, уламжлал”, “Монгол гэр бүлийн сурган хүмүүжүүлэх зүй” номнуудад давтан бичсэн тул энэ удаад товч авч үзэх нь зүйтэй гэж үзэв.

Эртний өвөг дээдсийн оромж сууцнаас гадна хадны зураг сүг, булш, хүн чулуу зэрэг түүх, соёлын дурсгал нь бичигдэл бус үеийн Өрх гэрийн түүхийг тодруулах хэрэглэгдэхүүн болж өгч байна.

Хадны сүг зураг

Эртний урлагийн гайхамшигт дурсгалын нэг болох хадны сүг зураг нь тэр үеийн хүний, гэр бүлийн аж амьдрал, хөгжлийг, ертөнцийг үзэх үзлийг ойлгон мэдэхэд тэргүүн зэргийн ач холбогдол бүхий чухал сурвалжийн нэг юм. Энэхүү дурсгалыг “хадны бичиг” гэж өвөг дээдсийн үеэс уламжлан нэрлэсэн байдаг нь ч учиртай хэрэг. Ер нь дэлхийн аль ч улс оронд хад чулуунаа зурж дүрсэлж, урлан үлдээсэн зураг сүгүүд нь “түүх бичлэг” болсоор бидний үеийг хүрсэн түүхтэй. Хүн амын дунд “Бичигтийн ус”, “Бичигтийн толгой”, “Бичигт хад” гэх зэргээр нэрлэж ирсэн газраас янз бүрийн дүрс бүхий олон зуун зураг сүг олдсоор байгаа нь судлаачдын анхаарлыг татсаар байгаа юм.

Хадны зураг сүг нь Монголчуудын эртний Өрх гэрийн, хүний амьдралын үйл явдлыг нүдэнд буухуйцаар тусгасан байдгаараа Монгол Гэр бүлийн нэгэнт өнгөрсөн түүхийн, соёлыг сэргээн ойлгох боломжийг хойч үедээ уламжлуулан үлдээсэн бүхэл бүтэн түүхэн шастир юм. Монголчуудын нутаг дэвсгэрээс олдсоор байгаа хадны зураг нь ялангуяа гэр бүлийн үүсэл, бүтэц, өөрчлөлт, ураг төрөл, эрхлэх аж ахуй, үр хүүхдийн сурган хүмүүжил гээд олон асуудалд аль нэг хэмжээгээр Монгол гэр бүлийн холын үүсэл, хөгжлийн зүй тогтлыг тодруулахад зохих хариу өгч чаддагт түүний ач холбогдол оршдог.

Ер нь хадны зурагт Өрх бүл, Гэр бүлийн гол шинж төрхийг олж харуулсан байдаг онцлогтой. Зургийг ажиглахад ямар зүйлийг илэрхийлсэн болох нь илтэд мэдрэгддэг. Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутаг Их баян уулын “Бичигтийн ам”-д доктор Н.Сэр-Оджав /1972 он/ илрүүлсэн зургаас үзвэл :

- Үржихийн билэгдэл болсон эрэгтэй, эмэгтэй хоёр хүний
- Гараа тэлэн хэвтэж байгаа эмэгтэй хүний /хоёр хөлний нь хооронд дугараг тэмдэг гаргасан нь төрж байгаа хүнийг мэдэгдүүлэх гэсэн бололтой гэж судлаачид үздэг/ зураг
- Хуруугаа сарвайлган, хоёр гараа сунган хөлөө тэлж хэвтсэн /төрж байгаа хүнийг харуулсан бололтой/ зураг
- Хэвтэж байгаа эрэгтэй, эмэгтэй /эрэгтэй нь ташаа тулан хөлөө агийлгасан, эмэгтэй нь хоср хөлөө тэлэх гараа өвдөгтөө хүргэсэн/ хоёр хүний /эр. Эмийн ажил хийж байгаа бололтой. Т.Н/ зураг
- Хоёр хөлөө тэлсэн хүний доор хөлөө нугалан хэвтэж байгаа хүний зураг дүрсэлжээ.

Доктор Н.Сэр-Оджав Баянлигийн хадны зургийн түрүү үеийнх нь хүрлийн сүүл үед хамаарагдах ба хожуу үе нь МЭ I мянган жилд холбогдмоор байна гэж /1957 он/ үзжээ.

Академич А.П.Окладников Улаанбаатар хотын өмнө орших Богд уулын ар бэл Их тэнгэрийн ам ба Туул гол руу цутгах гачууртын амны зосон зургуудын дөрвөлжин хашлага доторхи олон цэгийг тэр үеийн овог аймгийн гишүүдийн тоог төлөөлсөн⁴ гэсэн утга санааг, Академич Д.Дорж мал сүрэг өсөн үржиж нэмэгдээсэй гэсэн тухайн овог, аймгийнхны хүсэл эрмэлзэл бөгөөд энэ

4. А.П.Окладников. Древнемонгольский портрет, надписи и рисунки на скале у подножья горы Богд-Ула /Монгольский археологический сборник. М., 1962/. С.69

эрмэлзлэлээ мал сүргээ харгалзуулан өөрсдийн онгон болгож, тахин шүтдэг бүргэдэд давхар “даатгасан”⁵ гэж тайлбарласан байна.

Доктор Д.Цэвээндорж хашлага хүрэн дотор олон цэг, хэдэн хүн дүрсэлсэн буй нь хамтарч тариагаа боловсруулж байгаа буюу тариалангийн баяр ёслолыг тусгасан, шувуу бүргэд бол тухайн овгийг аюулаас хамгаалах гэсэн санаа⁶ гэж тайлбарлажээ.

Юутай ч овог аймгийн гишүүдийг тэнгэр эрхсээс ивээн тэтгэгч ер бусын ид шидтэй онго-нар, сар, од гаригийн биет төлөөлөгч шувууг шүтэж, уул ус бүхий тахилгат нутаг, овгийн гишүүдийг зураглан үлдээсэн байж гэж үзэж болох талтай.

Тэгэхээр ер нь ийм сэдэвтэй зураг овог аймгийн биеэ даасан байдлыг илэрхийлсэн утгатай юм. Түүхийн ухааны доктор Д.Гонгор “Халх товчоон” бүтээлдээ Монгол овгийн үндсэн шинжийн нэгийг :

- Сүлд туг, онгон шүтээнтэй. Жишээ нь: хиад боржигин овог цагаан шонхор шувуун онго /сүлд/ -той байсныг тэмдэглэжээ.

Их тэнгэрийн ам, Гачууртын ам, Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын нутагт орших зосон зургуудад тураг шувуун онготой овгийн гишүүд, хил хязгаарыг сахин хамгаалах сэдэвтэй, овгуудын биеэ даасан байдлыг илэрхийлсэн нь гол онцлог тал нь болж байна.

Ингэснээрээ хадны зураг нь эртний нүүдэлчдийн оюуны соёлын гайхамшигтай бүтээл мөний хувьд тухайн үеийн Өрх гэрийн үүсэл, амьдрал, аж төрөх ёс, зан заншил, овог, хүмүүсийн харилцааг ямар нэгэн хэмжээгээр сэргээн мэдэхэд чухал сурвалж юм.

Улаан зосоор зурагдсан зургийг Манай тооллын өмнөх III-II мянган жилийн үед хамааруулж байгаа нь одоогоос 6-5 мянган тэртээ овгийн байгуулал тогтсон байсныг нотолж байгаа юм.

Судлаач Т.Санжмятав “Монголын хадны зураг” /1995 он/ номондоо Архангай аймгийн Тариат сумын нутаг Суман галын хадны зураг /Зураг 1/-ийг “Олон хүнийг бүжиглэж байгаагаар дүрсэлсний дотор нэг хүнийг бусдаас онцгойлон том толгойтой, махлаг, их гэдэстэй дүрсэлсэн нь түүний овгийн гишүүдийн дунд үзэх байр суурийг тодорхойлосон бололтой” гэж үзжээ.



Зураг. 1

Архангай аймаг, Тулын булан. Бүлгээрээ явж байгаа олон хүмүүсийг зуржээ. Тэдний олонхи нь эмэгтэй хүн байх агаад жирэмсэн, төрж байгаа эх, зарим эрэгтэй хүн хоёр гараа дээш өргөн тэнгэрээс ивээн энэрэл хүссэн гэлтэй. Зарим хүмүүсийг толгой, бөгсөөр нь холбож зурсан зэрэг нь цусан төрлийн гэр бүлийн амьдралыг илэрхийлсэн бололтой.⁷

Хадны зургуудад овог аймгийн доторхи гэр бүлийн ураг төрөл хүмүүсийг харуулсан, эх үрсийн холбоо цөөн биш дүрслэгджээ.

Зураг 2. Хангай ба говийн зарим нутгийн хаданд эх хүнийг жирэмсэн гэж мэдэгдэхээр гол зураг, эмэгтэй хүний хөхийг онцлон үзүүлж, хүүгээ, хүүхдээ дагуулж яваагаар сийлж урлажээ. Хүнийг дүрсэлсэн хадны зурагт хүний аарцаг /хоёр хөлийн хооронд/ -ны дор бэлэг тус газар цэг /толбо/-ийг тавьсан нь хүүхэд төрхийг билэгдсэн гэж судлаачдаас үзэж байна. Хүмүүс өөрсдөө хүн болох, хөл тавьж амьдрах нөхцлийн нэгэнд үржих олшрохын билэгдэл зураг болох хүйс

5. Д.Дорж. Монголын хад чулуун дээрх зураг сүгийн зүйл. Түүхийн судлал. Т.VIII.1962.11 дэх тал.

6. Д.Цэвээндорж. Хадны сийлмэл зургийн шинэ дурсгалууд. Этнографын судлал. Т-V, Ф-5, УБ., 1977. зэрэг.

7. Т.Санжмятав. Монголын хадны зураг. УБ., 1995. 24 дэх тал.

ялгах тэмдгийг хэр томоор дүрслэн оруулжээ.

Хадны зураг дотор эрэгтэй, эмэгтэй хүний энгэр зөрүүлж байгааг янз бүрийн хэлбэрээр үзүүлсэн байдаг нь өнгөц харахад зугаа цэнгэлийн сэдэвтэй мэт боловч уг утгаараа үр хүүхэд бэлэгдэж удам угсаагаа залгамжлах, цусан төрлөө эрхэмлэсэн бололтой.



Зураг. 2

Хоёр хүнийг бэлгээр нь холбож зурсан нь нилээд байдаг нь сексийн амьдрал, гэр бүлийн аль ч хэлбэрийн үеүдэд анхаарал татдаг байсныг гэрчилнэ. Арга ч үгүй. Тухайн гэр бүлийн амьдралын тогтвортой байхын нэг нөхцөл сексийн харилцаа байсаар ирсэнтэй холбоотой.

Эх үрсийн сэдэвтэй холбогдох өөр нэг сонин зураг бол Өвөрхангай аймгийн нутаг Тэвш уулын хаданд том хүний цээж ба умайн тус газар хоёр хүүхдийн дүрс, Өмнөговь аймгийн нутаг Далан уулын нэгэн бяцхан толгойн хаданд том хүний цээжинд хоёр хүүхдийн дүрсийг сийлж урлажаа. Ийм агуулга бүхий зургуудтай төстэй зураг тус орны зэргэлдээх нутгуудаас олддог байна.

Эртний хүмүүсийн хооронд зурагт ажилагснаар эрчүүдийн хооронд эмэгтэй хүнийг /харамлах/ булаалдах явдал байжээ.



Зураг. 3

Овог түүний нутаг дэвсгэртэй салшгүй холбоотой асуудлын нэг нь орон байр юм. Эрт үеийн хүмүүсийн орон байр ямар хэлбэр, онцлогтой байсныг хадны зураг сүгийн дотор байгаа зарим дүрсээс мэдэх боломжийг эрхбиш олгож байна. Орон гэрийн үүслийг харуулахуйц нэг хэлбэр нь модны /шургааг/ оройн зөрүүдэн холбосон оромж- сууц юм.

Архелогич Ц.Доржсүрэн Говь-Алтай аймгийн Цагаан голын хадны зургуудын дотор байгаа гэрийн зургийн талаар бичихдээ тэр үеийн айлууд хэд хэдээрээ нэг дор айл буудаг байсан бололтой.



Зураг.4 “Цагаан хадны зураг”

Цагаан голын хадны зурагт модтой жижиг уулын хажуу бэлд их, бага хоёр гэр байгааг дүрслэн үзүүлжээ гээд дурсгалуудыг МЭӨ VII-V зуунаас наашхи мянгаад жилд холбогдуулан үзсэн байдаг. Орон гэрийн өөр нэг хэлбэр нүүдэлчдийн эсгий гэртэй төстэй зураг олдсоор байна.

Судалгаанаас үзэхэд эсгий гэртэй болохын өмнө гурван модны үзүүрийг зөрүүлэн холбож, доод талыг дэлгэн газарт шигтгэж, арьсан бүрээс нөмөргөн барьсан “овоохой” /урц/ орон, мөн мод зангидан барьсан сууц байсан нь гэр ба байшин хэлбэртэй байжээ.

Ер нь анхлан эртний хүмүүс газар гэртэй байсныг Монголын дорно зүгт олдсон газар /малтмал- эрүкэн сууц/ гэр харуулж байна.


Хүрэл зэвсгийн үед холбогдох хадан дээр зурагдсан орон сууцны дүрсүүд неолийн үеэс улбаатай болох нь судалгаанаас харагддаг. Хосолмол гэр бүл ханат гэр бий болгох эхлэлийг тавьсан нь зайлшгүй. Өөрөөр хэлбэл ханат гэрийн үүсэл нь хосолмол гэр бүлийн зайлшгүй үр дүн мөн.

Монгол нутгаас илрүүлсэн хадны зураг сүгт нүүдэлч Монголчуудын нутагт эрт цагаас бүлгээрээ гэр бүл бололцох ёсноос Хос бүлийн амьдралын, Өрх гэрийн өөрчлөл хувирлын урт замыг харуулсан онцлогтой байна.

Монгол орны газар бүрээс олдсоор байгаа хадны зураг сүг нь төв Ази – Монгол нутагт хүн гэр орноо үүсгэн амьдарч, аж ахуй, соёлоо хөгжүүлж, гэр бүлийн хөгжилд ихээхэн өөрчлөлт гарсаар ирснийг гэрчилэх түүх, угсаатны зүйн сурвалж, судлагааны хэрэглэгдэхүүн болж өгч байгаа юм.

Булш

- Увс аймгийн Чандмана уулнаас эрэгтэй, эмэгтэй хүнийг хүүхэдтэй нь, эрэгтэй эмэгтэй хамтад нь оршуулсан булш олджээ.⁸



Зураг.5 “Чандмана уулын булш”


8. Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Д.Цэвээндорж “Чандманы соёл” номондоо уг малтлагын талаар дэлгэрэнгүй бичсэн болно.

• Энд оршуулгын эмэгтэйчүүд гол төлөв 25-30, 35 насны, эрчүүд нь 35-45 орчим насны байжээ гэж эрдэмтэн Э.А.Новгородова тодорхойлжээ. Хамтад нь оршуулсан эрэгтэй, эмэгтэй хүний насны зөрүү ихэнхидээ 10-15 жил байгаа нь анхаарлыг татдаг.

• Археологич, Түүхийн ухааны дэд доктор Д.Навааны малтсан Хүннүгийн нэгэн булшнаас 25 орчим насны эрэгтэй хүний оршуулга олджээ. Уг хүний зүүн талын өвдөг дээр нэг, духан дээр нэг алтан ээмэг тавьсан байжээ. Үүнийг эмэгтэй /эхнэр/ нь харамсалаа илэрхийлсэн зан үйл гэж үзжээ.

Хүн чулуу

• Монгол Улсын нутагт байгаа Манай тооллын VI – VIII, XIII – XIV зууны үеийн зарим нэг чулуунд эмэгтэй хүний цээжин биеийг огт хувцасгүй нүцгэн байдлаар нүүр, үс гээг, хөх, эр хүний бэлэг эрхтний тэмдэг сийлэн өөд өөдөөс нь харуулан хүний хөлнөөс зайдуу газарт босгосон⁹ нь Монголчуудын гэр бүлийн хөгжлийг тодорхойлох нэгэн чухал хэрэглэгдэхүүн болох төдийгүй хос гэр бүл байсны илэрхийлэл болох юм.



Зураг.6 “Хос хүн чулууны хуулбар”

• Та бүгд мэдэж байгаа даа. Сүхбаатар аймгийн Дарьганга сумын нутагт байгаа Манай тооллын XIII – XIV зууны үед эхнэр, нөхөр буюу “ноён”, “хатан”-ы хөргийг дүрслэн эцэг “ноён”-ы талд хүүгий нь, харин эхнэр “хатан”-ы талд зүүн хойно нь бэр /эмэгтэй/-г хүүхэд барьсан байдалтайгаар харуулсан байдаг.

Хүн чулуу судлаач, Монголын эрдэмтэн Т.Баяр:

“... тэгэхдээ заавал эрэгтэй, эмэгтэй хоёр хүний хөшөө нэг дор байгаа нь нэн сонирхолтой” гээд үүний баримт гэвэл Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Сэнжмандал, Дорноговь аймгийн Саригхайрхан уул, Төв аймгийн Баян, Баянцагаан сумдын зааг Хүүхэнхонгор зэрэг газруудад буй хос хөргүүд бөгөөд эдгээр нь бидний бодлоор нэг гэрийн эр, эм хоёр буюу хаан,

9. Энэ тухай Говь-Алтай аймгаас УБДС-ийн түүхийн ангийг төгсгөсөн нэгэн шавь 1997 онд мэдээлсэн.

хатан хоёрын хөрөг бололтой”¹⁰ гэж тэмдэглэсэн байна.

МОНГОЛ ӨРХ ГЭРИЙН ТҮҮХ СУДЛАЛ

Төв Ази түүний дотор Монгол нутагт оршин амьдарч байсан хүний түүхийн ул мөр хүн төрөлхтний түүхэн хөгжлийн анхны шат болох хуучин чулуун зэвсгийн үеэс эхлэн урагшилан хөгжиж байсан нь тодорхой болсоор байна.

Сүүлийн үеийн судалгаагаар 800 000 мянган жилийн тэртээгээс Монгол оронд хүн гасралтгүй нутаглан аж төрсөөр иржээ. МЭӨ III мянган жил буюу шинэ чулууны үед төв Азид олон овог аймаг оршин байсан мэдээ эртний түүх сударт байгааг эрдэмтэд тэмдэглэж байна.

Монголчууд Өрх гэр нь төв Азийн нутаг, эдүгээгийн бидний өвөг дээдэс тулгын гурван чулуугаа тулан нэн эрт цагаас эх авсан арвин баялаг түүхтэй. Өнө эртний түүхтэй нүүдэлч Монголчуудын Өрх гэр нь Монгол хүний хөгжлийн оршин байх, амьдрахуйн өлгий болсоор иржээ.

Нийгмийн болоод хүний хөгжлийг гэр бүлийн хэлбэр, хэв маяг, оршин байхуйн уг чанартай холбон судлах гэсэн судлаач, түүхч, эрдэмтдийн бүтээл, оролдлого, түүхэн цаг үеийн огтлолцол бүрт үр дүнгээ өгч байсан байна.

Монгол Улсын хувьд:

• Монгол гэр бүлийг шинжлэх ухааны үүднээс цогц судалсан дорвитой бүтээл 1990-ээд он болтол бараг гараагүй байна. Түүхийн ухааны доктор Д.Гонгор гуай “Халх товчоон” /1974, 1978 он/ цуврал бүтээлдээ Халхчуудын VIII – XIV зууны тэргүүн хагасын үеийн өвөг дээдсийн түүхийг, түүний дотор “Монголын овог, ураг төрөл”, “Өрх гэр, гэрлэлт”-ийн ёс, уламжлалаас 2 бүлэг болгон оруулжээ. Энэхүү Монгол эрдэмтний бүтээл нь Монгол Өрх гэрийн түүх судлалын эхлэл болжээ. Уг судалгаа нь түүхийн үүднээс хийгдсэн болох тул Өрх гэрийн түүх судлалын арга зүйн үүднээс хандсангүй. Энэ нь ч зүйн хэрэг. “халх товчоон” бүтээлд нь манай тооллын VIII зуунаас өмнөх үеийн Өрх гэрийн түүхийн асуудал хөндөгдөөгүй байна.

• Академич Ш.Нацагдорж “Монгол феодализмын үндсэн замнал” гэдэг зохиолдоо : “Монголын феодализмын үүслийг зөвхөн XIII зууны үеэс огцом авч үзэлгүй, харин Монголын нутаг дэвсгэр дээр нүүдлийн аймгуудын улс төр оршин тогтнож, тэдгээрийн дунд их, бага ямар нэгэн хэмжээгээр үүсэн бүрэлдэж байсны зүй ёсны үргэлжлэл хэмээн үзсэн”¹¹ байна.

Энэ бүтээлд Нүүдэлчдийн хүйн үүсэл, онцлогийн асуудал хөндөгдсөн нь овгийн байгуулал /эцгийн эрхт ёсны/-ын үеийн Өрх гэрийн түүхийн судлалд ач холбогдолтой болсон байна. Түүхэн үйл явцын тухай эд өлгийн болон бичгийн дурсгал нь эртний Өрх гэрийн түүхийг танин мэдэхэд чухал ач холбогдолтой байдаг. Монголын археологчид, тухайлбал Х.Нэрлээ, Н.Сэр-Оджав, Д.Дорж, Ц.Доржсүрэн, Д.Наваан, Д.Цэвэцдорж нарын эрдэмтэд, судлаачид үнэлж баршгүй олдворуудыг илрүүлсэн, нээсээр байгаа нь Монголчуудын Өрх гэрийн эртний түүхийг улируулан судлахад үнэт хэрэглэгдэхүүн болж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

• “Монголын нууц товчоо”-ноос бид Монголчуудын Өрх гэрийн үүсэл, хөгжлийн талаар үнэж баршгүй мэдээ, бодит баримтыг олсоор байна. Нууц товчоог чухам Өрх гэрийн түүх судлалын үүднээс судлах ажил зохих ёсоор бараг эхлээгүй байна.

Цаашилбал Монгол Өрх гэрийн түүхийг судлахад Монголчуудын өөрсдийн нь хууль, тогтоомж, тухайлбал эхээрээ олдоогүй Монголын “Их засаг” болон “Монгол Ойрадын цаазын бичиг” /1640 он/, “Халх журам” зэргийг онцлон дурьдах хэрэгтэй.

10. Т.Баяр. Монголын чулуун хөрөг. УБ., 1996.486 дахь тал.

11. Ш.Нацагдорж. Монголын феодализмын үндсэн замнал. УБ., 1978.3 дахь тал.

Т.Намжил

“Алтан товч”, “Шар тууж” зэрэг нь Монгол Өрх гэрийн түүхийг судлахад чухал мэдээ баримтыг өгдөг.

Монгол Өрх гэрийн түүхийг судлахад юуны урьд Монгол сурвалж бичиг, зохиол тэргүүн зэргийн ач холбогдолтой.

- Эрдэмтэн Ч.Далай, Х.Пэрлээ, Х.Сампилдэндэв, Г.Сүхбаатар, Д.Цэрэнханд, А.Очир нарын эрдэмтдээс Монголын нүүдэлчид болон феодализмын үеийн судлалаар гаргасан бүтээлүүддээ овог, ураг төрөл, өрх гэр /айл, хот айл зэрэг/ язгуур асуудлыг анхаарч байсныг тэмдэглэх хэрэгтэй. Монголын түүх, Монголын угсаатны зүйн бүтээлүүд Монгол ёс заншилын их тайлбар толиудад овгийн байгуулал, өрх гэр, зан заншилын уламжлалаас тусгагдсан байна. Дээрхи зохиол, бүтээлүүд нь Монголчуудын өрх гэрийн түүхийг гэр бүл судлал, түүх, угсаатны болон угсаатны сурган хүмүүжүүлэх зүйн үүднээс судлах баазыг өргөтгөх ач холбогдолтой юм.

- Эдийн засгийн судлалаар академич Т.Намжил, доктор Г.Цэрэндагва болон судлаач Д.Төмөртоогоо нараас гаргасан зохиол бүтээлүүдэд Өрх гэрийн аж ахуйг хөндсөн байна. Эдийн засагчидад Монголчуудын эртний өрх гэрийн түүхийн судлагааг тухайлан анхаарагдаагүй байгааг буруутгах аргагүй.

- Академич Б.Ренчин, Ц.Дамдинсүрэн, Х.Сампилдэндэв, доктор Ц.Шагдарсүрэн гээд хэл судлаачид, Ч.Жүгдэр, Х.Нямбуу, Н.Хавх нарын философийн олон эрдэмтэд ураг төрөл, нүүдэлчдийн соёл иргэншлийн олон чухал асуудлыг авч үзжээ.

- Их гэр бүлд төвлөрсөн бүхэл бүтэн тогтолцоо болж боловсорсон Монгол гэр бүлийн сурган хүмүүжлийн өвөөс Э.Вандуй, Д.Дашжамц, Ж.Лувсандорж, Ц.Санжжав, Ш.Гаадамба, Б.Бор, Ш.Сүхээ, Г.Эрдэнэ-Очир, Ч.Жачин, Ц.Няндаг, Ш.Шагдар, Д.Баттогтох, С.Шагдартовуу, Х.Ховд-Абай гээд эрдэмтэд судалж олон тооны өгүүлэл, товхицоос эхлээд нэг сэдэвт зохиол туурвиж нийтийн хүртээл болгосон байна.

- Доктор Д.Майдар, судлаач Л.Дарьсүрэн нар “Гэр” зохиолыг бичсэнг дурдах хэрэгтэй. Монгол гэр бүлийн хосломол хийгээд хос гэр бүлийн үүсэл нь ханат гэрийг бий болгох шалтгааныг бий болгосон нь Гэр бүл – Ханат гэрийн хөгжил нягт уялдаатай байсныг гэрчилнэ.

- Монголын Нүүдэлчдийн түүхийн судалгааг XVIII зууны үеэс эхэлжээ гэж эрдэмтэд үздэг. Нүүдэл ёс, Монголын нүүдэлчдийн нийгмийн аж төрөх ёсны талаар олон ном, зохиол байдаг авч эдгээрийн дотор яг тухайлан Монгол Өрх гэр /Гэр бүл/-ийг түүх - угсаатны зүйн, гэр бүл судлалын үүднээс судалсан нь үгүй байна.

- Өрх гэрийн түүхийг Өрх гэр бий болж бүрэлдсэн түүхэн тодорхой нөхцөл байдалтай нь нягт холбож, тэдгээрийг харилцан шүтэлцээ, холбоо, хөгжил хөдөлгөөнд нь иж бүрнээр цогцтой судлан үнэлэх нь Өрх гэрийн түүх судлалын судалгааны ажлын арга зүйн онолын гол зарчим болж байх ёстой.

Гадаад орны хувьд:

Нүүдэлч Монголчуудын аж байдал, ёс заншил, зан үйл, амьдралын талаар түүний дотор гэрлэх ёс, өрх гэр, үр хүүхдээ хүмүүжүүлэх зэрэг уламжлалаас гадаад орны зарим аялан жуулчлагчид үлдээсэн нь бидний судлагаанд үнэт хэрэглэгдэхүүн болж байна. Энд онцлон Жиованни Дель Пано Картини “Монголчуудын түүх” /1245-1255 он/, Гильом Де Рубрук “Дорно этгээдэд зорчсон минь” /1253-1255 он/ зэрэг тэмдэглэл, Рашид Ад Дины “Судрын чуулган” зэрэг түүхэн сурвалжуудыг нэрлэж болно.

Гадаад орны эрдэмтдийн дотор нүүдэл ёс, монголын феодализм хийгээд нүүдэлчдийн нийгмийн аж төрөх ёсны талаар үнэтэй чухал зохиол туурвисан эрдэмтэд цөөнгүй байна.

Тэдгээрийн дотор Оросын эрдэмтэн Н.Я.Бичурин¹² төв Азийн ард түмний соёлын өвөрмөц байдал, академич Б.Я.Владимирцов¹³ нүүдэлчдийн нийгмийн байгууллыг шинжлэх ухааныг анх удаа судалсан байна. Г.И.Рамстед¹⁴, Ш.Ивамура¹⁵, Ц.Д.Номинханов¹⁶ зэрэг ураг /урук/-ийг нилээд судлажээ.

Гадаадын эрдэмтэдээс гаргасан Монголын түүх, хэл, соёлын талаархи олон талын зохиол бүтээлүүдэд тухайлан нүүдэлч Монголчуудын Өрх гэрийн эрт үеийн түүхийг гэр бүл судлал, түүх, угсаатны зүйн үүднээс судалсан нь төдийлөн үгүй байна. Монголчуудын Өрх гэрийн зан заншил, хүмүүжлийн уламжлалын асуудлаар сүүлийн хориод жилд, тухайлбал :

- Зөвлөлтийн /хуучин нэрээр/ Кон зэрэг судлаач эрдэмтэд Монголчуудын хүмүүжлийн уламжлалт арга, хэлбэрээс судалж

- Оросын Холбооны Улсын Чуваш, Буриад Монгол, Якут /Саха/, Тува, Киргиз, Халимаг, Хакасияд Монгол ардын сурган хүмүүжлийн асуудлаар судалгаа хийгдэж, угсаатны сурган хүмүүжүүлэх зүй /этнопедагогика/-н суурь тавьж

- БНХАУ-ын ӨвөрМонголын өөртөө засах оронд малчин ардын сургах ёсны уламжлал, ардын сурган хүмүүжүүлэх арга ухааны асуудлаар

- БНСУ, Япон зэрэг улсад угсаатны болон гэр бүлийн сурган хүмүүжүүлэх чиглэлээр нилээд бүтээлүүд гаргасан байна. хийгдсэн зарим судалгаа, нийтлэгдсэн ном, бүтээлүүд нь Монголчуудын Өрх гэрийн түүхийн талаархи судалгааны баазыг ямар нэгэн хэмжээгээр өргөтгөхөд тус болж байна.

Монгол Улсад өрнөсөн ардчилал өөрчлөлийн жилүүдэд Монгол Өрх гэрийн ёс заншил, уламжлал, орчин үеийн асуудлыг гадаад орнуудад тухайлбал, Орос, Япон, БНСУ, Герман, Польш, Франц, АНУ зэрэг олон улсад улам илүү сонирхох боллоо. Дээрхи улсаас Монгол гэр бүл судлалаар магистарын зэрэг хамгаалсан байна.

Япон улсад Монголч нэрт эрдэмтэн Шиниши Койбучи өөрийн санаачлага, оролцоотойгоор Монголчуудын гэр бүлийн уламжлал, шинэчлэлийн асуудлаар 3 удаа эрдэм шинжилгээний хурал хийлгэжээ.

Ойрын 10-15 жилд Монгол Улсад төдийгүй Ази тив, дэлхий дахинаа Гэр бүлийн асуудал улам нарийсан, төвөгтэй болох төвөгтэй болж байна. Ийм таамаглал Монголын болоод Ази, Европ, Америкийн гэр бүлийн уялдаа холбоог судлах тусам гарч байгаа юм.

Бидний судлагааны явцад Монголчуудын Өрх гэр /Гэр бүл/-ийн уламжлал нь Азийн хийгээд Европын орнуудынхтай харилцан нөлөөтэй байсан нь харагддаг.

“Монгол орны нүүдэлчид өрнө, дорно дахины иргэншлийн уулзвар нутагт оршиж”¹⁷, “Монгол орон түүхийн олон үе цагийг дамжин урт замыг туулахдаа ЕвроАзийн олон улс оронтой аль нэгэн талаар харилцаа холбоотой”¹⁸ байжээ.

Тэгэхээр биднээс Монгол Өрх гэрийн түүхийн судалгааг, үйл ажиллагаа дэлхийн суёад орнуудынхтай ямар нэгэн хэмжээгээр холбогдож байх учиртай болж байгаа юм. Ямар нэгэн ард түмний аж төрөх ёсыг хөдөлмөрийн хүйсийн хуваарь, гэр бүл, өрх бүлийн харилцаа, ёс заншил зэргийг харгалзан үзэхгүйгээр судалж болохгүй юм. Эдгээрийг судалдаггүй байгалийн, нийгмийн болон хүмүүнлэгийн ухааны нэг ч салбар үгүй гэхэд хилсдэхгүй. Угсаатны зүй, нийгэм судлал, хүн ам зүй, эртний судлал, түүхийн ухаан, утга зохиол судлал, аман зохиол

11. Н.Я.Бичурин. Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена. М –Л. 1950-1953.

13. Б.Я.Владимирцов. Общественный строй Монголов /Монгольский кочевой феодализм/. Л. 1934.

14. G.I.Ramstedt6 Kalmukischen wörterbuch. Helsinki. 1935.

15. Ш.Ивамура.“Монгол шакой кэйзай ши кэнкю” /Монголын нийгэм – эдийн засгийн судалгаа/. Киото.

16. Ц.Д.Номинханов. Материалы к изучению истории Калмыцкого языка. М., 1975.

17. Г.Сүхбаатар. Монгол Нирун Улс. УБ., 1992. 234 дэх тал.

18. Н.Сэр-Оджав. Монголын эртний түүх. УБ., 1977. 4 дэх тал.

судлал, хэл шинжлэл гээд цөм л өрх гэр, гэр бүлийн тодорхой хэсгийг хөндөж байдаг.

Өрх гэрийн түүх судлал нь Гэр бүл судлалын онолын асуудлуудад тулгуурлаж нийгмийн түүх судлалын хүрээнд хөгжиж буй мэдлэг дундын салбар хэмээн үзэж болно.

Энэ нь Өрх гэрийн түүх судлалын судлах зүйл, зорилтоос урган гарч байгаа юм. Монголчуудын Өрх гэрийн түүх судлалын цаашдын чухал зорилтын нэг бол Монголын байгаль, нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны салбартай хягт ажиллах явдал юм. Монголчуудын угсаа гарвалын судлагаанд зохих хувь нэмэр болсон доктор Ж.Батсуурийн судалгаа¹⁹ нь Монголын байгалийн шинжлэх ухааны эрдэмтэд Монголын Өрх гэрийн түүхийн судалыг хөгжүүлэхэд өргөн боломж байгааг харууллаа.

Угсаа гарвалын судлал нь хүн, удам угсаа, овог, төрөл садан, айл өрх гээд олон асуудлыг олон талаас нь судлахад ач холбогдлоо өгч байна.

Гэр бүлийн судлал, түүний дотор Өрх гэрийн түүхийн судлал түүхэн угсаагны зүйн улмаар нийгмийн түүхийн шинжлэх ухаантай нягт хөгжих болж байгаа нь бидний анхаарлыг зүй ёсоор татаж байгаа болно.

Жишээлбэл : “Өрх бүл” гэх нийгэм, түүхэн ойлголт гэхэд л их агууламжтай. “Өрх гэр” гэсэн ухагдахуунаас нийгэм, түүх, овог /эхийн болон эцгийн эрхт ёс/-ийн байгуулал, хүн, ураг төрлийн холбоо, гэрлэлт, ёс заншил гээд олон ойлголтууд гарч ирж байгаа юм. Тэгэхлээр Өрх гэр бүл цогцолбор, динамик шинжтэй ойлголт юм. Чухам ингэж хандах юм бол Өрх гэрийн өөрийн нь мөн чанарыг гаргаж чадна. Өрх гэр өөрөө зохион байгуулагдсан систем мөн.

Сүүлийн үед Гэр бүл судлалын шинжлэлд арга зүйн шинэ хандлага гарч байгаа нь Монголын Өрх гэрийн эртний түүхийн судалгааг хөгжүүлэхэд ач холбогдолтой юм.

Өрх гэрийн түүх судлалыг түүхэн хүн судлалын хандлагатай болгохыг анхаарах шаардлагатай болж байна. Систем арга нь Өрх гэрийн түүх судлалын арга зүй болох учиртай.

Нэгэн Өрх гэр гэхэд эцэг /нөхөр/, эх /эхнэр/, үр хүүхдүүд, цөм хоорондоо харилцаар, амьдарч ажиллахдаа харилцан дэм болсоор, садан болсоор байдаг нь зохион байгуулагдсан хүмүүсийн систем нийлбэр болдог. Нийгмийн ухааны онол, арга зүйн шинэ хандлага нь Монгол Өрх гэрийн түүхийн судлалд шинэ боломжийг нээж өгнө.

А.Я.Гуревич /Франц/ түүхийн судлагааг овог, аймаг, хүй, гэр бүл, нөхөр мэтийн тухай бичил түүхийн судалгаа болгох талаар санал дэвшүүлсэн байна.²⁰

Нүүдэлчдийн түүхийг судлахдаа Академич Ш.Нацагдорж гуайн онцлон тэмдэглэснээр “тэдгээрийг дотор нь ялгаж салгаж үзэхгүй, нийтэд нь хавтгайруулдагаас нүүдэлчдийн энэ тэр хэсгийн нийгмийн хөгжлийн товшинг тодорхойлохдоо алдаатай дүгнэлтэд хүрэх явдал цөөнгүй байна”²¹. Ингэж хандсанаас эртний өрх гэр, түүний үүсэл, бүтэц, хэлбэр, онцлог, хөгжлийн онцлогийг хайхрахгүй ерөнхийлөн «овгийн байгуулал» хэмээн бичих нь олонтаа болжээ.

Австрийн Вена дахь Нийгмийн түүх, эдийн засгийн институтын эрдэм шинжилгээний ажилтан, гэр бүлийн түүх судлаач Райнхард Зидер Нийгмийн түүхийн салбарт “Гэр бүлийн түүх судалгаа”-г нэг гол чиглэл болгохын төлөө олон жил ажилласны дүнд Баруун, Төв Европын сүүлийн хоёр зуу гаруй жилийн гэр бүлийн нийгмийн түүхийн асуудлаар туурвисан бүтээлдээ гэр бүлийн хөгжлийн түүхэн гол /гэрийн хөдөлмөр, эцгийн эрхт ёс, нийгэм, гэр бүлийн тогтолцоон дахь хувьсал, гэр бүлийн эзлэх байр суурь, гэрлэлтийн зан үйл, үх хүүхэд

19. Ж.Батсуурь. Монголчуудын өлгий нутаг, гарал үүслийг генетикийн судлагаагаар мөшгөсөн нь, - Дорно дахины судлалын асуудал. 1988, №1(18). 8-9 –р тал.

20. А.Гуревич. Историческая наука “Историческая антропология, Социальная история” историческая наука, Вопросы философии. 1988, №1, 1990, №4

21. Ш.Нацагдорж. Монголын феодализмын үндсэн замнал. УБ., 1978.18 дахь тал.

ахмадын харилцаа, бэлгийн харьцаа зэрэг/ асуудлыг бичжээ.²²

Р.Зидерийн Гэр бүлийн нийгмийн түүхийн талаар хийсэн судлагаа нь ЕвроАзийн Гэр бүлийн түүхийн судлалд шинжлэх ухааны арга зүйн ач холбогдолтой юм. Зарим эрдэмтэдийн дунд нүүдэлчдийн нийгмийн байгууллын бүтцийг хэдэн мянган жилийн турш огт өөрчлөгдөхгүй уламжлан ирсэн гэж тайлбарладаг тал байна. Тийм биш юм. Тухайн нэг орноос, түүхийн тодорхой эрин үеийн хүмүүсийн оршин сууж байгаа нийгмийн ёс журам нь нэгэн талаар Өрх гэрийн хөгжлийн шатаар нөхцөлдөж байдаг.

Нийгмийн хөгжлийн үе шат бүхэнд Өрх гэр нь хөгжин хувьсаж байдагийн зэрэгцээ нийгмийн харилцааны тусгал болж байдаг. Тийм учраас Өрх гэрийн хөгжил, хувьслыг цаг хугацааны дэвсгэр дээр ангилан үзэх нь Өрх гэрийн түүх болдог.

“Нэг орны, түүхийн тодорхой эрин үеийн хүмүүсийн оршин сууж байгаа нийгмийн ёс журам нь нэг талаар өрх гэрийн хөгжлийн шатаар нөхцөлдөж байдаг.

Ф.Энгельс

Монголчуудын Өрх гэр нь олон зууны туршид хувьсан өөрчлөгдөж ирсэн түүхтэй болх учраас түүний түүхэн хөгжлийн шатыг үечлэн тус тусад нь судлах нь шинжлэх ухааны ач холбогдолтой.

Г.Морган эцгийн эрхт ёсон дээр үндэслэн омгийн урьдах шат нь эхийн эрхт ёсон дээр үндэслэсэн анхны омог байсныг нээсэнг Ф.Энгельс балар эртний түүхэнд нэн чухал болохыг тэмдэглэсэн байдаг.

Өрх гэрийн түүхийн судлалын үндсийг тавигчдын онол арга, зүйд тулгуурлан Монголчуудын эртний Өрх гэрийн түүхэн хөгжлийг :

- Эхийн эрхт ёсны үе дэх Өрх гэр /нэн эртнээс хүрлийн үе/
- Эцгийн эрхт ёсны үе дэх Өрх гэр, гэр бүл /хүрлийн үеэ манай тооллын XII зуун/ гэж үечилэн судлах нь зүйтэй гэж үзэв. Ингэж үечлэн судлах ч боломжтой. Учир нь :

Нэгдүгээрт: Балар эртний Өрх бүлийнхний байдалтай зэрэгцүүлэхэд овгийн байгуулал (эхийн болон эцгийн эрхт ёс тогтож байсан, феодалын харилцаа үүссэн) нь нүүдэлч Монголчуудад хөгжлийн шинэ хэлбэрүүдийг авчирч өгсөн байна Энэ үеүдэд нүүдэлчид урагшилан, ялангуяа Өрх бүл, өрх гэрийн харилцаанд томхон өөрчлөлтүүд гарсан онцлогтой.

Хоёрдугаарт: МЭ XII зуунаас өмнөх үе бол Нүүдэлч Монголчуудын түүхэнд эргэлт гарч, Монголд овгийн байгуулал задарч эцгийн эрхт ёсны /хос гэр бүл/ үе тогтож, феодализмд дэвшин шилжих, феодалын харилцаа тогтож эхэлсэн түүхэн чухал үе юм.

Гуравдугаарт: Монголд феодализмын харилцаа XIII зуунаас өмнө Хүннү улсын үеэс үүсч, хөгжиж байжээ гэж Монголын түүх бичлэгт тэмдэглэгдэх болсон байна. “Түүхийг үечлэх нь түүний үе тус бүрийн онцлог шинжүүдийг нээн гаргаж, танин мэдэж, түүгээрээ дамжуулан судалж байгаа болон танин мэдэх гэж буй зүйлийн мөн чанарт нэвтрэн орох нэгэн боломжийг бүрдүүлдэг байна”.²³

“Түүхийг үечлэх нь түүний үе тус бүрийн онцлог шинжүүдийг нээн гаргаж, танин мэдэж, түүгээрээ дамжуулан судлаж байгаа болон танин мэдэх гэж буй зүйлийн мөн чанарт нэвтрэн орох нэгэн боломжийг бүрдүүлдэг байна.”

22. Р.Зидер. Социальная история семьи Западной и Центральной Европе /конец XVIII-XX вв/. Пер.с нем. Л.А.Овчинцевой. М., 1997.

23. Монгол Улсын түүх, МУИС. УБ., 2006.

Т.Намжил

МОНГОЛ ӨРХ /ГЭР/ БҮЛИЙН СУДЛАЛ- ОРЧИН ҮЕ

Өрх гэр нийгэм доод шатнаас дээд шатанд дэвшин хөгжихийн хирээр доод хэлбэрээс дээд хэлбэрт шилжиж байдаг.

Өрх гэрийн талаар гарсан дэвшилтийг тусгаж, өрх гэр эрс өөр болсны дараа төрөл садангийн систем эрс өөрчлөгддөг жамтай. Чухам энэ үүднээс үзвэл Монгол оронд нийгмийн өргөн хүрээнд гүнзгий, эрч өөрчлөлт явагдаж байна.

Гэр бүлүүдэд эрс өөрчлөлт гарах эхлэл тавигдаж байна. Тэгэхээр ураг төрлийн холбоонд үндэслэгдсэн садан-төрөл-хамаатны систем хэрхэн өөрчлөгдөх нь вэ? гэж хүлээлгүй хариуг огөх ёстой. Үе үеийнхний хөндийрөл нэмэгдэх хандлага бий боллоо.

Ойрын ирээдүйд /15-20жилд/ эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн шинэ үе бий боллоо.

XXI зуунд эр, эмийн харилцааны хэлбэрийн тухай бидний таамаглан бодож болох зүйл, хөгжлийн хандлага ямар чиглэлтэй байж болох вэ?

Юуны өмнө эмэгтэйчүүдийг мөнгөөр буюу нийгмийн эрх мэдлийн хэрэгслээр худалдаж авахгүй болох эрэгтэйчүүдийн шинэ үе, нөгөөтэйгүүр жинхэнэ дурлалаас өөр ямар нэгэн түлхээсээр эр хүнтэй бие нийлэхгүй, эдийн засгийн үр дагавраас /эмэгтэйчүүд эдийн засгийн талаар дарлагдаж ирсний үр дүн нь эр, эм хоёрын эрхийн тэгш бус байдал байсан/ айж дурласан эрэгтэй хүнийгээ ойр дотно байхаас татгалзахгүй болох эмэгтэйчүүдийн шинэ үе эхлэнэ. Эдгээр шинэ үеийнхэн явал зохихоо өөрснөө мэдэх болно. Энэ үндсэн дээр ямар саналтай байхаа Ф.Энгельсийн хэлснээр боловсруулах болно.

Морганы бичснээр Соёлжилтийн үед хөгжсөн нийгмийн байгууллагуудыг түүхийн үүднээс судлах явдал номын хүрээнээс халина.

Өрх гэрийн цаашдын хөгжлийн шинэ үе эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд бүрэн тэгш эрхтэй болох явдлаар эхлэнэ.

• Глобаль хөгжлийн орчин дахь монгол гэр бүлийн хөгжил, төлөвшлийн асуудал нь өөрөө манай нийгмийн хөгжлийн нэг зангилаа асуудал болон тавигдаж байгаа юм.

Гэр бүлийн нийгмийн үүрэг өсөн нэмэгдэхийн хэрээр түүний хөгжлийн зүй тогтол, нөлөөлөгч гадаад ба дотоод хүчин зүйлүүдийн судалгаанд өгөх ач холбогдол ч мөн нэгэн адил өсч байна.

• Монгол өрх гэрийн түүх судлалын асуудлыг Төв Ази тухайлбал Монгол орноор хязгаарлан үзэж болохгүй нь мэдээж бөгөөд тэд нартай Евразийн суурьшил ба нүүдэл олон овог аймаг их, бага аль нэг хэмжээгээр холбоотой тул зөвхөн үе цагийн хувьд бус мөн газар нутгийн хувьд өргөн цартай авч үзэх хэрэгтэй болно. Ийм учраас харилцан хэлхээ холбоотой байж, бие биедээ соёлынхоо нөлөөг аль нэг хэмжээгээр тусгаж байгаа эртний овог, аймгийн эдийн засаг, нийгмийн байгуулал, соёл, ушсаа гарвалын асуудлыг судлахын тулд нэгэн сэдэв, нэгдсэн төлөвлөгөөтэй судалгааг Монгол, Өрнө, дорнын орнуудад хийх нь шинжлэх ухаанд илүү ач холбогдолтой.

Нүүдэлч Монголчуудын балар эртний Өрх гэрийн судлалыг гүнзгийрүүлэхэд хүн судлагчид, эртний нийгмийн мэргэжлийн түүхчид, эрх судлагчид нэгдэн нэмэгдээсэй.

Гэвч тус зохиол Монгол оронд олон зуун жилээр шргэншин суусан нүүдэлчдийн ээдрээтэй урт түүхэн замд хөгжиж ирсэн Эртний Өрх гэрийн түүхийг бүхэлд нь нягтлан судлаж чадаагүй нь мэдээж бөгөөд зохиогч тийм зорилго тавиагүй, тэр нь нэг хүний гүйцэтгэх ажил ч бус юм.

Баримт бичиг, эрдэмтдийн судалгаанаас үзвэл Монгол улсад Монгол гэр бүл судлал үүсч, хөгжихийн эхлэл тавигдаж байгаа ч, Монгол өрх гэрийн түүх судлалын суурийг хяналтын идэвхи хүчээр багтай тавих шаардлагатай болох нь харагдаж байна.

Зохиогч “Монгол Өрх гэрийн түүх” хэмээх бүтээлдээ XII зуунаас өмнөх буюу балар эртний үеийн нүүдэлч Монголын эхийн эрхт болон эцгийн эрхт ёсны үе дэх Өрх гэр /гэр бүл/-ийн асуудлыг авч үзэх анхны оролдлогыг хийлээ.

Монгол Өрх гэрийн хөгжил, хувьсал, өөрчлөлтийг он цагийн хувьд нааш улируулан “XII-XVII зууны үе”, “XVII-XX зууны эхэн үе”, “Социализмын үе”-ийн гэх шатаар судлах шаардлагатай юм.

Чухам ингэж чадваас хойч үедээ “Монгол Өрх гэр” гэсэн түүхтэй боллоо гэж омог бардам хэлэх юмтай болно.

Монгол Өрх гэр тэгэж үүсч, хувьсан өөрчлөгдөж иржээ гэдгийг мэдэх нэг хэрэг. Харин энэ нь Өрх гэрийн цаашдын хандлагад практикийн төдийгүй шинжлэх ухааны ямар ач холбогдолтой вэ? гэсэн асуулт зүй ёсоор гарч ирж байгаа юм.

Г.Морган хэрэв өрх гэр дөрвөн хэлбэрийг дараалан туулаад тав дахь хэлбэртэй байгаа тэр баримтыг зөвшөөрөн хүлээвэл, энэ хэлбэр цаашдаа удаан хугацаагаар үргэлжлэн байх уу? гэдэг асуултыг өөртөө одоогоос 140-өөд жилийн өмнө XIX зуунд тавьсан байдаг.

Тэгвэл хүн төрөлхтөн даяараа XXI зуунд орж нийгэм өөрчлөгдөн хөгжсөөр. Морганы тавьсан асуултанд XXI зууны нийгмийн хөгжлийн хандлагыг баримжаалан өрх гэрийн өнөөгийн бүтэц, хэлбэрүүд нийгмийн хэрэгцээг хангаж чадах уу, ямар шүү чиг баримжаатай байх вэ? гэдэг үүднээс хариулах ёстой.

Зохиогч “Монгол гэр бүлийн ёс, уламжлал”, “Монгол гэр бүлийн сурган хүмүүжүүлэх зүй”, “Монгол Өрх гэрийн түүх” гэсэн бүтээлүүдийг түмэн олондоо өргөн барьлаа. Гэхдээ нийгмийн түүх үргэлжилсээр, өөрчлөгдсөөр, хөгжсөөр л...

Дэлхийн улс түмнүүдийн адил Монголын ард түмэн шинэ эрчтэй хөгжил, эрч шинэчлэл өөрчлөлтийн үе – XXI зуунд шилжин орж байгаа үед өрх гэрүүд маань мөн л өөрийн хөгжлийн эгзэгтэй шатанд нэгэнтээ орлоо.

Учир иймээс Монгол Өрх гэрийг анхаардаг эрдэмтэд, миний гэр бүл судлалаар бэлтгэгдсэн шавь нар дотроос Монгол гэр бүлийн өөрчлөлт, хувьсалт, төлвийг үргэлжлүүлэн улам өргөн хүрээтэйгээр “Өнгөрсөн –Одоо –Ирээдүй” гурван цагийн холбоонд нь судлаж, тулгамдсан асуудлуудад хариу өгсөөр байна гэдэгт гэр бүл судлаач эрдэмтний хувьд бат итгэлтэй байна.

Өрх гэр нь нийгэм хөгжихийн хирээр хөгжиж, нийгэм өөрчлөгдөхийн хирээр өөрчлөгдөж байх жамтай. Яагаад вэ? гэвэл Өрх гэр /гэр бүл/ нь “нийгмийн тодорхой системийн бүтээгдэхүүн мөн учраас түүний хөгжлийн байдлыг тусгаж байх болно”²⁴

Өрх гэр хэзээ ч өөрчлөлтгүй байдаггүй.

*Монголчуудын маань удам эрүүл, ухаан саруул,
ажил үйлс нь орнуун бадарч байх болтугай.*

ЭШИЛЭН ХЭРЭГЛЭСЭН БҮТЭЭЛИЙН НОМ ЗҮЙ

Нэг. Монгол хэлээр:

1. Ж.Батсуурь. Монголчуудын өлгий нутаг, гарал үүслийг генетикийн судалгаагаар мөшгөсөн нь.
- Дорнодахины судлалын асуудал. 1988, №1 (18)
2. Д. Баяр. Монголын чулуун хөрөг. УБ., 1996.
3. Д.Дорж. Монголын хад чулуун дээрх зураг сүгийн зүйл.

24. Ф.Энгельс. Өрх гэр, хувийн өмч, төрийн үүсэл. /К.Маркс, Ф.Энгельс. Түүвэр зохиол. III. УБ., 1971. 305 дахь тал.

Түүхийн судлал. Т.8. 1962

4. Монгол Улсын түүх. МУИС УБ., 2006.

5. Ш.Нацагдорж. Монголын феодализмын үндсэн замнал. УБ., 1978.

6. Т.Санжмятав. Монголын Хадны зураг. УБ., 1995.

7. Г.Сүхбаатар. Монгол Нирун улс. УБ., 1992.

8. Н.Сэд-Оджав. Монголын Эртний түүх. УБ., 1977.

9. Д.Цэвээндорж. Хадны сийлмэл зургийн шинэ дурсгалууд.

Этнографын судлал. Т.V. ф.5. УБ., 1977.

10. Ф.Энгельс. Өрх гэр, хувийн өмч, төрийн үүсэл. /К.Маркс,

Ф.Энгельс. Түүвэр зохиол./ III. УБ., 1971.

Хоёр. Гадаад хэлээр:

11. М.Я. Бичурин. Собрание сведений о народах, обитавших в Средней

Азии в древние времена. М-Л. 1950-1953.

12. Б.Я.Владимирцов. Общественная строй монголов. Монгольский

кочевой феодализм. Л. 1934.

13. А.Гуревич. Историческая наука и историческая антропология;

Социальная история и историческая наука, - Вопросы философии. 1988.№1. 1990. №4.

10. Зидер. Социальная история семьи Западной и Центральной Европе /конец XVIII- XX вв/.

Пер.с.немц. Л.А.Овчинцевой.М., 1997

11. Ш.Ивамура. Монголын нийгэм эдийн засгийн түүхийн судалгаа

(Монгол шакой кэйзай ши кэнкю). Киото.

12.Ц.Д.Номинханов. Материалы к изучению истории Калмыцкого языка.

М., 1975.

14.А.П.Окладников. Древнемонгольский портрет, наджим и рисунки на

сколе у подножья норы Богдо Ула. /Монгольский археологический сборник/. М. 1962.

14. G.I.Ramstedt.Kalmükischen wörterbuch. Helsinki. 1935.

15. PETROGLYPHS IN THE WULANCHABI GRASSLAND. Gai shanlin. Beijing. 1989

HISTORY OF MONGOLIAN FAMILY

The issue of Mongolian family has been written incidentally in works and studies of Mongolian researchers and studiers. The reason to write this book is lack of works and studies about history of Mongolian family in Mongolia.

The origin of family and its change as well as relative structure and its feature of the period of nomadic Mongolian clan structure /both of matriarchal and patriarchal systems/ are written in this book from family, historical and ethnic point of view based on the archeological findings.

I have tried to determine the similarities between nomadic Mongolian and Eastern/Westerns families' tradition and customs in the book.

The book includes the defining dictionary of words related to the study of history of Mongolian family.

The book is for researches and studiers /students, masters and doctorates/ who study and interested in nomadic Mongolian culture and civilization.